



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/765

Булган сум

Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "в", 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал тооллогын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Аймаг, орон нутгийн эдийн засгийн голлох салбар болох мал тооллогын бэлтгэл ажлыг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, мал тооллогод бүрэн хамруулах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч буй зөрчил дутагдлыг газар дээр нь залруулж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг мал тооллогын Ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

4. Мал тооллогыг зохион байгуулахад шаардагдах зардал 9,070,312 (есөн сая далан мянга гурван зуун арван хоёр) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

5. Мал тооллогын ажлыг аргачлал, маягт заавар, арга зүй нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явц, сан бүрдүүлэлт, үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллахыг Статистикийн хэлтэс (М.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

6. Мал тооллогын урьдчилсан дүнг 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор, нэгдсэн дүнг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar 70x11 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324011130

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 02 ны/ний өдрийн 1/26 дугаар
захирамжийн хавсралт



2024 оны мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын ажлыг зохион
байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:
Ажлын хэсгийн орлогч дарга:
Гишүүд:

О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч дарга)
М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)
Д.Батцогт (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)
Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
Д.Лхагвасүрэн (Татварын хэлтсийн дарга)
Ш.Ганбаяр (Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа)
Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга,
дэд хурандаа)

Нарийн бичгийн дарга:

Ц.Батчимэг (Статистикийн хэлтсийн Хөдөө аж ахуй
хариуцсан мэргэжилтэн)